

## УЛС ТӨР БА АЙДАС

Ё. ДОВЧИН

Профессор, МУИС. Улс төр судлалын тэнхим

Б. БАТМЭНД

Улс төр судлалын тэнхимийн магистрант

**Түлхүүр уг:** Улс төр, айлас, улс төрийн мөн чанар, хүмүүний оршихуй

**Хураангуй:** Аливаа бодгаль амиа хамгаалан өөрийгөө тэтгэж буй нь байгалиас засасан эрхэм чанар, үүрэг бөгөөд өөрийн оршихуйг мэдрэх боломж сорилт юм. Харин хүмүүний хувьд нийгмийн орчинд ая тухтай амьдарч улмаар би оршин байна гэдгээ илэрхийлэх гэсэн хүсэл тэмүүлэл нь улс төр болж илэрдэг билээ. Иймд улс төрийн үүсэл чухам ямар учир шалтгаантай, бидний амьдралд ямар үүрэгтэй бол гэх асуулт энэхүү өгүүллийн сэдэл болсон юм. Улс төрийн мөн чанар, үүрэгт нөлөөлж болох хүчин зүйлсээс улс төр ба айдсынхарилсан хамаарлыг улс төрийн шинжлэх ухааны аргазүйд тулгуурлан судлахыг зорьсон болно.

\* \* \*

Аристотель “улс төр гэдэг бол төрийн бүх ажил хэрэг..төгөлдөр сайхан амьдрал зохиод чиглэгдсэн нийт иргэний харьцахуй юм. Энэ бол улс төрийн харьцахуй. Иймд улс төр бол хамтын үйл ажиллагаа мөн. Улс төрийн зорилго нь нийтийн сайн сайхан байдлыг хангах явдал юм. Улс төр гэдэг бол бүх нийтийн тэгш ёсыг хэрэгжүүлэх зорилго бүхий хамтын үйл ажиллагаа юм.”<sup>1</sup>

Аристотелийн үзэл санаа хүний уг чанар, ёс суртахууны философитой холбогдож гарч ирдэг. Мөн тэрбээр юмын мөн чанар бол түүнийг байгаагаар нь ойлгох явдал юм гэж үзсэн байдаг. Иймд улс төрийн мөн чанар бол хүмүүсийг сайн сайханд хөтлөж, өөрсдийн аж амьдралыг бүрэн дүүрэн утгаар авч явах боломж бололцоо бүхий нийгэм, журмыг цогцлоон аж төрөхөд чиглэгдэхэд орших учиртай билээ.

Өөрөөр хэлбэл хүн байгалийн нөхцөлд ганц нэгээр оршин, амьдарч амьд үлдэх боломж бага гэдгийг ухааран ойлгож, нийгмийн амьдралыг цогцлоо болсон нь улс төрийн харилцаа болж хөгжиж иржээ.

Үнд нөлөөлсөн зарим хүчин зүйлсийг ойлгосноор улс төрийн мөн чанар, улс төрийн систем, улс төрийн тогтвортой байдал зэргийг судлахад чухал чиг баримжаа болох билээ.

Басхүү эртний Грекийн хот улсын үед улс төр, ардчилал гэх зэрэг ойлголт үүсэн бий болсон нь эдийн засгийн хөгжлийн оргил үетэй холбогдох бөгөөд эндээс эргэцүүлэн бodoход гарч байгаа нь хүн эрх мэдэлд хэт шунах, эсвэл амиа бodoх нь улс төрийн мөн чанар огт биш, харин нийгмийн дийлэнх олонх төвшин сайхан, сэтгэл тэнэгэр, амар жимэр амьдрахыг хүсэж байдаг нь түүний мөн чанарыг илэрхий болгож хүмүүний амьдрал, оюун санаанд улс төрийн гүйцэтгэх үүрэг нь улам бүр тодорч, хүмүүс өөрийн оршин амьдарч буй улс төр, нийгмийн зохион байгуулалтанд үнэлэлт дүгнэлт өгөх, шүүн тунгаах чиг баримжааг олж авах бололцоо гарч ирдэг.

Нөгөө талаар улс төр нийгмийн үзэгдлийн хувьд түүнийг өрнүүлэн нөлөөлж байдаг хүчин зүйлсийн нэг бол айдас хэмээх сэтгэлзүйн ойлголт болохыг тодруулан судлахыг зорьлоо.

Нийгмийн амьдралын өөрчлөлтөөс зөрчил, асуудал байнга урган гарч, зарим талаараа амьдралын өрсөлдөөн, хөдөлгөгч хүч нь “Улс төр” болж байдаг нь засгийн эрх баригчаас чадамж, чадвартай байхыг шаардлаг.

Мөнхүү эрх мэдэл хэний гарт буйгаас хамаарч, улс төрийн мөн чанар, хувь заяа хэрхэх нь тодорхойлогдож, үр нөлөө нь нийгмийн амьдралд илэрч байдаг нь жам ёсны үзэгдэл гэлтэй.

<sup>1</sup> Аристотель. Улс төр. УБ, 2006.11, 17, 28 –р тал

\*\*\*

Айдас олон янзаар үүсэж болох бөгөөд зарим тохиолдолд сэтгэл санаанаас, тухайлбал айсан хүнд аргаль хөдлөнө гэдэг шиг гэхдээ бидний авч үзэх айдас нь нийгмийн орчны таагүй байдлаас буй болдог айдсын талаар юм. Учир нь улс төрд айдас нөлөөлж болохыг Роберт Дуглас Хайншилвүүд phobia буюу айдас нь хүмүүст хүчтэй нөлөөлдөг бөгөөд нийгмийн олонхийн дунд тодорхойгүй байдлаар айдас бий болж улмаар айдсаар дамжуулан улс төрийн зорилгодоо хүрч болох талаар дурдсан байдал.

Тэрээр дэлхийн нэгдүгээр дайны дараах 1934 оны Германы нийгмийн нөхцөл байдлыг жишээ болгон авсан байна. Тухайн үед дэлхийн эдийн засгийн хямрал, Герман улс дэлхийн нэгдүгээр дайнд ялагдсан зэрэг нь ард иргэдийн дунд бухамдал бий болгон улмаар бүгд тодорхойгүй айдаст автаж, одоо бид яах вэ гэх асуултын улс төрийн шийдэл буй болсон нь Германд нацист дэглэм тогтох үндэс болсон гэж үзсэн.

Ийнхүү нацист намын суртал ухуулга нь нийгмийн айдсыг улс төрийн арга хэрэгсэл болгон ашиглаж улмаар Германы нийгмийн хямрал еврейчүүд буруутай гэхсуртал ухуулгад тулгуурлаж хүмүүсийг айдаст автуулснаар засгийн эрхийг гартаа авч чадсан гэж тайлбарласан байна.<sup>2</sup>

Үүнээс үзэхэд нийгэмд айдас үүсэх нь хүчтэй, дарангуйлагч төрийг бий болгох үндэс болдог бол нөгөө талаас төр, засгийн эрх баригчдын үйл ажиллагаа явцгүй, иргэдийн эрх, эрх чөлөө, аюулгүй байдал баталгаагүй үед хүмүүс айдаст автдаг.

Тухайлбал.

- айдас засаглалын арга хэрэгсэл болдог.
- Хямралт байдалд айдас олон түмний бухамдалыг төрүүлж, үймээнд самуунд хүргэх талтай.
- Хүмүүс амьдрах баталгаа байхгүй, хууль нь хэрэгждэггүй улс оронд амин хувшиа бодож, өмч хөрөнгө, амь нас, ажил алба минь хэрхэх бол гэсэн сэтгэл санааны дарамт, айдаст автаяад хүргэдэг.

Иймээс айдас олон түмний санаа бодолд сөргөөр нөлөөлж улмаар хүмүүс улс төрийг буруу, зөрүү ойлгосноор улс төр бохирдож байдал.

\*\*\*

Хүний анхдагч айдас бол араатан амьтад, байгалийн элдэв үзэгдлийг даван туулах байсан бөгөөд энэхүү айдас, бидний оршихуйн төлөөх тэмцэл зориг, хамтын амьдралыг цогцлоо арга ухаан буюу улс төр нөлөөлсөн байна.

Учир нь хүн нийгмийн амьтан байхыг хүсээд, эсвэл сонгосон явдалд бус амиа алдах вий гэсэн айдас амьдарч оршихын төлөөх тэмүүлэлийг төрүүлж, улс төр нь нийгмийн амьдралын зохион байгуулалтын үндэс болж хөгжсөн байна.

Энэ нь хүмүүс анх нөөцийг овгийн бусад гишүүнээсээ илүү эзэмшсэнээрээ амьд үлдэх боломж өсөн нэмэгдэж, байгалийн хүчин зүйлсийг даван гарахад тус дөхөмтэй болохыг ойлгож, бидний ухамсарт уламжлагдан төлөвшиж ирсэн нь өнөөгийн нийгэм, хувь хүний амьдралд нөлөөлж байдал “Улс төр” гэх ойлголтын язгуур эхтэй холбоотой болохыг илэрхийлж байна.

Т. Гоббс, Ж. Локк<sup>3</sup> байгалийн жам ёсны үеийн хүмүүсийн аж байдал, дүр төрхийг өөр өөр үндэслэл, гаргалгаанд тулгуурлаж тайлбарласан байдал.

Т. Гоббс 1648 өөрийн “Левиафан” бүтээлдээ...Хүн хүндээ чоно, хүн байгалиас аймхай хулчгар, залжин амиа бодсон зэрэг нь аажимдаа нийгмийн гэрээ хийж улмаар төр үүсэхэл хүргэсэн гэж үздэг.

Т. Гоббсын дээрх үзэл санаа нь нийгмийн амьдрал тогтвортгүй, хүний амиа алдах вий гэсэн айдас нь хүчтэй үед хүн амиа бодсон, залжин шунахай болдог гэсэн гаргалгааг харж болохоор байна. Мөнхүү Т. Гоббс өөрийн бүтээлийг туурвиж байх үед Англи улсад олон түмнийг хамарсан үймээн самуун өрнөж байсан нь нөлөөлсөн ба басхүү нийгмийн амьдралын орчин нөхцөл хэт таагүй, хүмүүсийн сэтгэлзүй айдаст автаяад нь дээрх үр дүнд хүргэдэг гэдгийг илэрхийлж байна.

Харин Ж. Локк дээрх үзлээс ялгаатай нь байгалийн жам ёсны үед хүмүүс эрх тэгш, ёс зүйтэй хамтран амьдарч байсан, хүн бие бялдар хүч чадлын хувьд гэхээсээ илүүтэйгээр эрх тэгш байдалтай оршиж байх нь чухал гэж үзсэн байдал.

Дээр өгүүлсэнчлэн хүмүүсийг сайн сайханд хөтлөж, нийгмийн төгөлдөр зохион байгуулалтыг үүсгэж

<sup>2</sup> R.D. Hinshelwood. Ideology and identity: A psychoanalytic investigation of a social phenomenon 2009 Palgrave Macmillan 1088-0763 Psychoanalysis. Culture & Society Vol. 14, 2, 131–148 дэлгэрэнгүй үзнэ үү.

<sup>3</sup> Д.Бодл-Эрдэнэ. Улс төрийн философи. Удиртгал. УБ. 2015. 278, 300 дахь дэлгэрэнгүй үзнэ үү

улмаар хүмүүс ёс суртахуунлаг байж хамтаар зохистой амьдрах нь улс төрийн мөн чанар юм бол ямар тохиолдолд бөрчлөгдөх вэ? гэсэн асуултыг төрүүлж байна. Монтескье "...мөн чанар гэдэг нь юмыг байгаагаар нь авч үзэхийг хэлнэ, зарчим гэдэг нь хөдөлгөх аргыг нь хэлнэ. Эхнийх нь түүний өвөрмөц байгуулал юм, хоёр дах нь түүнийг хөдөлгөдөг хүний тэчъяадал юм."<sup>4</sup>

Үүнээс үзвэл хүний нийгмийн мөн чанар бол зохион байгуулалттай, зохистой хамтаар орших бол хүний байгалиас заясан мөн чанарын хувьд амиа хамгаалан тэтгэж, оршихуйн тухай юм. Иймээс хүн бол оюун ухаант амьтан бөгөөд өөрийн хүсэл сонирхлыг удирдаж байдгаас улс төр рациональ, иррациональ шинжийг агуулдаг бөгөөд энэ тохиолдолд хүний амьдарч буй орчин, оюун санаа, сэтгэл зүйд айдас нөлөөлж давамгайлвалусл төр бохирдож, улмаар ард иргэд улс төрийг амин хувийн ашиг хонжоо хайсан зорилгын арга хэрэгсэл гэж ойлгож улс төрд оролцох эсвэл эс оролцох динамик өөрчлөлтийг илэрхийлж байна.

Өөрөөр хэлбэл хүн амиа алдах вий гэх айдас яваандаа "Хүн хүндээ чоно" болоход хүргэдэг бол, нөгөө талаас хүн өмч, амь нас, эрх чөлөө зэргээ алдахаас айдагнь улс төрийг өрнүүлж бидний амьдралд хүчтэй нөлөөлж байдгыг илтгэж байна.

Иймээс хүмүүс төрд айдсаар захирагдаг бол чадамжгүй сүл төрийн хүмүүс айдаст автан амиа бодож хичээх эсвэл хэт улс төржих хандлага ажиглагддаг байна.

Иймээс ч Монтескье "эзэрхэг засгийн мөн чанараас үүдсэн цорын ганц зарчим бол айдас гэж үзсэн. Айдас бол дарангуйлагчийг ч, түүнийг аялдан дагалдагчийг эзэмдэж байдаг. Нэг ёсондоо айдас бол эзэрхэг засгийн хөдөлгөгч хүч болдог. Бүгд найрамдах улсад буянт үйл, хаант улсад нэр төр хэрэгтэй байдаг бол ганцаар эзэрхийлэх засгийн газарт айдас хэрэгтэй. Эзэрхэг засагт сайн үйл шаардлагагүй, нэр төр бол түүнд аюултай"<sup>5</sup>

Өөрөөр хэлбэл Төр-Иргэн хоорондын харилцаа нь ямар байгаагаас шалтгаалж тухайн нийгэмд оршиж буй улс төрийн мөн чанар, үүрэг мөн тийм хэр хэмжээнд байдаг гэж үзэж болох юм.

Судлаач Д. Ганхуяг өөрийн цахим тэмдэглэлдээ: хүн бүр айдаг тэр тусмаа төрөөс, даргаасаа аиж захирагдах тал бий хэмээжээ...<sup>6</sup> энэ нь улс төрд зарим талаараа айдас нөлөөлж байдгыг илэрхийлж байна.

Мөнхүү айдсаар захирна гэдэг нь ямар нэгэн байдлаар хүн ёсны сайн үйл, хүний эрх, эрх чөлөө, өмч, амь нас зэргийг ямар ч баталгаагүй болгож байгаа хэрэг нөгөө талаас бүгд найрамдах төр гэж тунхаглаад эрх баригчид нь үүргээ үл биелүүлэх аваас ард иргэдийн дунд амиа бодох байгалийн анхдагч зөн совин хүчтэй сэргэхэд нөлөөлдөг.

Энэ нь Т. Гоббсын "хүн хүндээ чоно байх" тэрхүү дэглэмийн үндэс тавигдаж байгаа бөгөөд харин хатагтай Ан Сан Су Чи хэлсэнчлэн "Дүр эсгэсэн ардчилал дарангуйллаас илүү хор хөнөөлтэй"<sup>7</sup> гэдэгтэй дүйх болно.

Ж. Локкын эрх чөлөөтэй байх, амьд явах, өмчтэй байх нь хамгийн чухал төр тэдгээрийг хамгаалж байх үүрэгтэй боловч төр өөрийн үүргээ баталгаатай биелүүлэхгүй бол хүмүүс хэт улс төржих аль нэг нам бүлэг, явцуу байдлаар талцаж улмаар эрх мэдэлд хүрч, өөрийн хувийн ашиг сонирхлоо хэрэгжүүлэх гэдэг нь улс төрийг огтоос өөр болгож байна.

Энэ бүхэн гагшүү төр өөрийн үүргээ зохистой биелүүлэх чадамжгүй байгаа нөхцөлд айдас улс төрд нөлөөлөхөд хүргэдэг гэдгийг илэрхийлж байна.

\* \* \*

"Улс төр нь хүн үүсч, хүний хэл яриа бий болж, хүмүүс орчиндоо дасан зохицох болон өөрийгөө хамгаалах амьдралын амин хэрэгцээнээс үүдсэн хүмүүсийн хоорондын харилцаа (ан ав, хоол хүнс, эд баялаг, ахуй амьдрал, оюун санааны) үүссэн тэр цаг үеэс эхлэн тооцогдох нэн эртний үндэс улбаатай үзэгдэл юм."<sup>8</sup>

Гэхдээ эрт үеийн хийгээд өнөөгийн улс төр гэх ойлголтонд хамаарах утга, илэрхийлэл нь зарим талаараа ялгаатай болохыг соёл иргэншлийн түүхэн хөгжлөөс мэдэж болно.

Хүн сүргийн гишүүн бүр амиа алдах вий гэх айдас, мөн амьдарч оршихуйн төлөөх арга ухаан нь улс төрийг үүсгэгч шалтгаан бөгөөд хамтаар амьдарч, оршин тогтонохын төлөө байх нь улс төрийн мөн чанар, үндсэн зориулалт, үүрэг нь болжээ. Нийгмийн амьдралын хөгжлийн явцад хүн байгалийн хүчин зүйлс, араатан амьтадаас амиа хамгаалах бүрэн боломж, бололцоотой болсон нь анхдагч айдасаасаа тодорхой төвшинд ангижирах суурь нөхцөл тавигдэжээ. Гегель нэгэнтэй "Оюун санааны мөн чанар нь үйл ажиллагаа

<sup>4</sup> Шарль Монтескье. Хуулийн Амин сүнс. УБ. 2008. 29-30 дах тал

<sup>5</sup> Шарль Монтескье. Хуулийн Амин сүнс. УБ. 2008. 39 дах тал

<sup>6</sup> <https://ganaa.mn/2009/04/24/qwepinhkl/>

<sup>7</sup> <http://www.news.mn/r/142360>

<sup>8</sup> Д. Болд-Эрдэнэ. Улс төрийн философи: Удиргал. УБ., 2015 12 дах тал

билээ. Оюун санаа нь субъект ч, объект ч мөн, субъект болохын хувьд өөртөө тэрээр объект бүтээж, объект болохын хувьд өөрийгөө танин мэддэг юм”<sup>9</sup>. Хэмээсэн нь дээрх утгатай дүйж байгаа билээ.

Хүмүүсийг амиа хамгаалах зорилго нь нэгтгэж байсан бол алсдаа анхдагч айдасыг мартаж, нийгэмд олон талын ашиг сонирхол бий болж, хүний оюун санаа сэтгэхүйн цар хүрээ тэлж, бүтээн туурвиж эхэлсэн нь нийгмийн ялгаралыг бий болгож, зарим нэг нь давуу байдал олж авах болсноор улс төр нь зөвхөн төр засгийн хүрээнд илүү идэвхтэй ажиглагдаж, улс төрийг засаглалтай холбон авч үзэх ойлголт, хандлага илүү давамгайлахад зарим талаараа нөлөөлжээ.

Хүнд “Эд хөрөнгөө алдчих вий, цөллөгдчих вий, боолчлогдож бусдын эрхшээлд автах вий гэх айдсыг байнга мэдэрч явдаг хүмүүсийн амьдрал түгшүүрээр дүүрч, нойргүйдэж, идэж ухаа ч больдог байхад, ядуучууд, цөллөгийхөн, боолчууд сэтгэл амар явж л байдаг.”<sup>10</sup>

Энэхүү хэсгийг эргэцүүлвэл хүчтэй салхи гарахад талд ургасан овс бүгд нэгэн зүгт ханддаг шиг олон түмэн нэгнээ даган шийдвэр гаргах хандлага давамгайлж, чухам миний, бидний эрх ашиг аль нь бол, аль нь илүү амьдралд зохистой оновчтой шийдвэр болох талаар дүгнэлт хийх боломж бага байдаг.

Учир нь хүн хэзээ хүсэл сонирхлоо мэдэж, оршиж байгаагаа ойлгодог вэ? гэдгээс хамаарч улс төрд оролцох зорилгоо тодорхойлж сонгодог юм. Энэ нь хүн өөрийн гэсэн өмч, ажил төрөл, байр суурь, орон гэртэй болох үед л биежиж утга учраа бүрэн дүүрэн олох үндэс суурь болдог билээ.

Ард иргэд амьжиргаа, ахуйн хувьд хангалаун бол эд хөрөнгө, өмчөө алдчих вий, байр суурь, ажил алба минь хэрхэх бол гэх айдас нь хариуцлага, ёс зүйтэй улс төрд хандах үйл явцад ахиц дэвшил гарахад нөлөөлж болох билээ. Иймээс чинээлэг дундаж давхарга оршиж буй улс оронд засаглал, улс төрийн цэвэр орчин, улс төрийн оролцооны зохистой байдлыг тэнцвэржүүлж чадсанд мөн чанар, үр өгөөж нь илэрч байгаа юм.

Балчир хүүхдийг амархан айлгаж, эсвэл инээлгэж үгэндээ оруулж болдгийн адил амьжиргааны хувьд дорий олон түмний сэтгэлзүйд амархан нөлөөлж, засгийн эрх мэдлийг авч байсан нь түүхэн баримтууд байдаг.

Басхүү улс төрийг жигших хандлага бий болсноор ард иргэд өөрсдийн хувь заяаг зөнд нь орхиж, аажмаар нийгмийн оюун санаа эзгүйрэх үед улс төрийг орлох өөр номлол, шашин, явцуу үзэл суртал газар авч, үнэн бодит байдлаас хэт хөндийрсөн сонголт хийж төр засаг солигдох, нийгэмд дарангуйлал тогтох аюул нүүрлэдэг байна.

Учир нь улс төрийн үйл явцад хүний оюун санаа, сэтгэл хөдлөлийн аль нь илүү давамгайлж буйгаас хамаарч шинж байдал нь хувирч, түүхийн үйл явцад үр нөлөө нь илэрдэг ажээ.

Б.Чимиid гуай “Хэрэв улс төр жам ёсоороо оршин хөгждөгсөн бол амьсалахад цэвэр агаар, цэцэг навч, цэнгэг ус юутай ч зүйрлэшгүй чухлын адил улс төрийн эрүүл саруул орчин нь ард олны амар түвшин амьдрахуйн гол орчин, нөхцлийн нэг мөн билээ.”<sup>11</sup> хэмээжээ. Үүнээс үзэхэд улс төрийн мөн чанар, нийгмийн амьдралын хөгжил дэвшил салшгүй харилцан хамаарлтай болохыг илэрхийлж байна.

Хүмүүний хувьд амиа хамгаалан, өөрийн ахуйг тэтгэж, зорилгодоо хүрэх бодлого боловсруулж буй оюун ухааны төгөлдөр үйлдэл нь улс төр болж байгаа юм. Иймд ямар ч улс гүрэн, нийгэмд хүний улс төрийн эрх, эрх чөлөөг боогдуулж хязгаарлана гэдэг бол улс төрийн мөн чанарт сөргөөр нөлөөлж байгаа хэрэг билээ. Иймээс ч Аристотель “Хүн бол уг чанартай төр улсын амьтан мөн”<sup>12</sup> хэмээжээ.

Мөнхүү улс төр хүний уг чанартай уялдан, бодлого үйл хөдлөл болж илэрдэг гэсэн санаа. Хүн өмч хөрөнгөө алдах вий, ажил албан тушаалаа алдах вий гэсэн айдас нь түүнийг үйлдэл хийхэд хүргэж байгаа бөгөөд энэ бол улс төрийн зан үйлдлийн шинжтэй, нөгөө талаар хүн өөрт байхгүй зүйлийг олж авсанаар илүү сайн сайханд хүрнэ гэдэг бодол, үйлдэл нь зорилгын шинж чанартай учир бас л улс төр болж байгаа юм.

Гэхдээ хүн болгонд засаглах хүсэл байна уу?, засаглах тийм амар хялбар ажил уу? гэдгээс улс төрийн мөн чанар, хэрэгцээ зориулалт улам тодрон гарах билээ.

Улс төр ба айдасын харилцан хамаарлын үр дүнд улс төрийн мөн чанар, үүрэг зориулалтанд өөрчлөлт орж байдаг юм. Нийгмийн орчины хэт таагүй нөхцөл байдлаас үүдэн хүний сэтгэлзүйд айдас зонхилох нь амин хувши хэт бодож улс төрд оролцох эсвэл улс төрд сэтгэл хөөрлөөр оролцох үзэгдлийг бий болгож улс төрийг гажуудулахад хүргэдэг.

Иймээс ч амин хувийн үзэл, ажил албан үүргээ ялгаж ухамсарласан жинхэнэ улс төрийн элитийг бэлтгэж

<sup>9</sup> М.Ф.Овсянников. Гегель. УБ., 1987. 155 дах тал

<sup>10</sup> Мишель до Монтень. Сонгомол эссеинүүд. УБ., 2005. 66 дах тал

<sup>11</sup> Б. Чимиid. Өнөөгийн улс төр хуульчийн нүдээр. УБ., 2006. 57 дах тал

<sup>12</sup> Аристотель. Улс төр. УБ., 2015. 10 дах тал орч Б. Даш-Ёндон. дэлгэрэнгүй үзүү

төлөвшүүлэх нь улс төрийн мөн чанар, үүрэг зориулалтаараа орших боломжыг бүрдүүлж, сэтгэл хөдлөлийн шинжтэй бус бодож, төлөвлөсөн бодлого хөтөлбөр хэрэгжиж, иргэд улс орны хөгжлийн төлөө оролцох улс төрийн орчин нохцөлд улс төр үр өгөөжтэй байх хөрс суурь бүрдэнэ.

Хүн болгон ямар нэгэн зорилго тавьж, түүнийхээ төлөө санаа тавьж байдаг нь хүн нийгэмд би оршиж байгаа юм шүү гэдгээ л хүрээлэн байгаа хүмүүстээ илэрхийлэх гэсэн үйлдэл нь улс төр бодог юм. Францын сэтгэгч Р. Декартын хэлсэнчлэн: “Би сэтгэж байна, тийм учраас оршиж байна”<sup>13</sup>. Өөрөөр хэлбэл хүмүүний оршихуйн төгөлдөр үйлдэл бол улс төр юм. Яагаад гэвэл хүн өөрийн оршихуйг олон арга замаар илэрхийлэх боловч амиа хамгаалан тэтгэж, амьдарч оршихуйн төлөө л тэмүүлж байдаг болохоор билээ.

Тиймээс “Гегель нэгэнтээ түүхэн дэх субстанци зүйлийг танин мэдэх ёстой, харин ер нь субстанци зүйл гэдэг бол байгальд ч, хүний нийгмийн түүхэнд ч өрнөн хөгжиж байдаг оюун санаа юм.”<sup>14</sup> Гэсэн нь нийгэм, улс төрийн хөгжлийн үйл явц, ойлголт ухагдахуун нь оюун санаанаас үүдэлтэйг илтгэж байна.

Мөнхүү тухайн нийгэмд өөрийн аж амьдрал, оршихуйг ямар арга замаар авч явж буйгаас хамаарч тэрхүү улс орны улс төрийн хөгжлийн төвшин, онцлог шинж нь бүрэлдэн тодорч, зарим талаараа улс төр хүн амын амьдралын хэв маяг, утга учирын илэрхийлэх болдог билээ.

М.Вебер: “Улс төрийн “төлөө” амьдарч байгаа хүн “үүнээс амьдралаа бүтээж” байгаа бөгөөд хэрэгжүүлж буй засгийн эрхийг барьж байгаадаа сэтгэл ханаж байдаг, эсвэл “үйл хэрэг”-т хүчин зүтгэж байгаагаа ухамсарласнаас өөрийн үнэ хүндийн мэдрэмж болон дотоод түвшин байдлаа олж авч улмаар амьдралаа утгатай болгодог гэсэн үг”<sup>15</sup> хэмээжээ. Үүнээс үзэхэд хүн бүр адилгүй, хүлэг бүхэн жороогүй гэдгийн ашилаар хүн болгоны улс төрийн оролцоо, ойлголт өөр байдгийг илэрхийлж байна.

Тэгвэл улс төр жинхэнэ ёсооороо нийтийн сайн сайхны үйл хэрэгт зориулагдаж байж, төрийн бодлого үр өгөөжөө өгч, олон түмэн сэтгэл тэнэгэр, амар жимэр оршихуйн тухай юм. Иймээс л нийгмийн хөгжлийн явцад арчилал бий болсон нь зүгээр тохиолдолын хэрэг бус хүн төрөлхтөний улс төрийн хөгжил жам ёсоороо урагшилж, ахин дэвшиж буйг илэрхийлж байгаа чухал үйл явц юм.

Өөрөөр хэлбэл анх хүн сүргийн үед ганц нэгээрээ амьд үлдэх шаардлага тулгарч, бүхий л оюун санаагаа төвлөрүүлэн зориулж байсан бол хүмүүс хамтаар нийгэм, улс орон болон хөгжин аж төрөх нь ганц чиний амьд үлдэх нь үндсэн зорилго бус нийтийнх болсонд улс төрийг ойлгох зөрчил, эргэцүүлэл оршиж байгаа гэлтэй.

## Дүгнэлт

Хүн анх байгалийн элдэв юмс үзэгдэл, араантан амьтадаас айж, хамтаар амьдрах нь амьд үлдэх, орших илүү боломжтойг ойлгож мэдсэнээр нийгмийн амьдрал хөгжиж, улс төр үүсэхэд айдас маш хүчтэй нөлөөг үзүүлсэн нь дамжигүй билээ.

Хүний оюун санаа, сэтгэхүйн цар хүрээ тэлэх тусам, амьдралын үйл явц улам бүр баяжиж ирсэн ба хүн зэр зэвсэг хийж, хоол хүнсээ нөөшлөж, өөр бусад зүйлсийг бүтээх боломж бүрдجээ.

Гэхдээ хүн ашиг хонжоо хайх, албан тушаал эрхлэх зэрэг үйлдэл нь түүний муу муухай чанараас үүдэлтэй бус чухамдаа хүн байгалийн анхдагч өгөгдөл, нийгмийн бүрэн эрхт гишүүн гэдгээ мэдрэн ойлгох шалгуур боломж буюу амиа хамгаалан, тэтгэж өөрийн оршихуйг илэрхийлж буй үйлдэлтэй салшгүй хүйн холбоотой юм.

Иймээс ч улс төр түүхийн үйл явц, нийгмийн амьдралд хүчтэй нөлөөлж, хүмүүс өөрсдийн оюун санаа, амьдралаа улам баяжуулан ухаажиж байдаг.

Улс төрийн мөн чанар, орчин болон улс төрийн оролцооны үйл явцад сэтгэлзүйн талаасаа айдас хүчтэй нөлөөлж, улс төрийг сэтгэл хөдлөлийн шинжтэй тогтвортгүй болгож, нэг эсвэл хэт амин хувна хичээсэн зорилгын арга хэрэгсэл, эсвэл үймээн самуунд хүргэж болзошгүй нь улс төрийн мөн чанар, үүрэг зориулалтыг огт өөр болгож улмаар олон түмэн улс төрийг буруу ойлгож, түүнээс хүнийсэн төсөөрч эхлэх сөрөг үзэгдлийг бий болгодог.

Ингээд иргэд улс төрөөс хүнийсч эхлэх нь эрх баригчдад хариуцлага тооцох, тэдний бодлого үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, эсвэл ашиг сонирхолоо нэгтгэн, илэрхийлэх зэрэг улс төрийн системийн чухал үйл явц, чиг үүрэг алдагдах, эсвэл иргэд олон нийт улс төрд хэт оролцож, эрх баригчдад зүтгэж, тэднийг тойрон хүрээлж амьдрал ахуйгаа сайжируулах гэсэн арга зам болж, олон түмэн ашиг сонирхолын явцуу хүрээнд талцан хуваагдаж, улс төрийн мөн чанар, зүй ёсны байдалд сөргөөр нөлөөлдөг.

<sup>13</sup> Философи. У.Б., 2014. 116 дах тал Орч. Б. Батчулуун энэхүү номноос дэлгэрэнгүй үзнэ үү.

<sup>14</sup> М.Ф.Овсянников.Гегель.У.Б., 1987155 дах тал орч А. Энхбаатар

<sup>15</sup> М. Вебер. Улс төр бол мэргэшил мөн. шинжлэх ухаан бол мэргэшил мөн. У.Б., 2000 19 дах тал



Монхүү төр өөрийн үүргээ сүл биелүүлэн чадвар, чадамж багатай байх нь хүмүүс өөрийн эрх чөлөө, өмч, амь нас зэргээ баталгаа бага байгааг мэдэрч эхэлсэнээр хүний ёс суртахуунлаг, сайн чанар алдагдаж нийгэмд хэт амиа бодож хувна хичээж эхлэх нь улс төрийг бохирдуулах аюултай юм.

Иймээс Монголын төр, засгийн эрх баригчид ард иргэдийн эрх ашгийг хамгаалж хүний эрх, эрх чөлөөг бодит амьдрал дээр хэрэгжүүлэн хангаж хамгаалах нь чухал бөгөөд улс төрд айдасын нөлөөлөлийг багасгаж, нийгэмд хүн айх аюул багатай амар тайван амьдарч улмаар өөрийн аж амьдралыг бие даан авч яван, төрийн үйл хэрэгт оролцож улс орон нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулах боломж бүрдэх болно.

Үүнд:

- Иргэдийн улс төрийн талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэх тал дээр эрх баригчид, эрдэмтэн судлаачид соён гэгээрүүлэх ажлыг эрчимтэй өрнүүлэх
- Иргэдийн амьжирагааны төвшинг сайжируулж, улс орны эдийн засгийн чадавх, бололцоог дээшлүүлэх
- Үндсэн хуулинд заагдсан хүний эрх, эрх чөлөөг нийгмийн амьдралд бодитоор хэрэгжихэд эрх баригчид улам анхаарч ажиллах зэрэг юм.

Дээрх үйл хэргийг хийж эхлэх нь Монголын нийгэмд алс хэтдээ тохиож болох улс төрийн тогтвортгуй байдал, улс төрийн хямрал зэргээс сэргийлэн Монголын онцлогтой ардчилалыг төлөвшүүлэх хөгжлийн үйл явцад дорвitoй суурь алхам болох учиртай билээ.

Басхүү улс төрд оролцох тэгш боломж, зохистой орчиныг бүрдүүлж өгөх нь чухал бөгөөд эрх баригчдыг илүү хариушлагатай байлгаж, улс төрийн орчинд тодорхой зөв дэг соёл тогтоож, ёс зүйтэй хандах нь улс төрийн хөгжлийн үйл явцад маш чухал ач холбогдолтой юм.

Мөнхүү иргэд ахуйн хувьд чинээлэг байх нь улс төрийн талаарх зохистой мэдлэг, ойлголттой болоход чухал түлхэц үзүүлэх бөгөөд улс төрийн мөн чанар, үүрэг зориулалт жинхэнэ утгаараа нийгмийн амьдрал бидний оюун санааны төвшинд орших ба энэ ч ёсоор **Хүмүүний оршихуйн төгөлдөр үйлдэл** бол “Улс төр” мөн.

**Резюме:** Содержание данной статьи состоит в вопросах, основанные на жизненных позициях и политических реалиях. Основными направлениями, влияющие на политическую устойчивость являются сущности Ее, политическая система, политическая стабильность. Главными целями изучения уровня политической науки основываются на политической сущности и меры воздействия, охватывающие безопасную стабильность политической системы.

## НОМ ЗҮЙ:

1. Аристотель. Улс төр. УБ., 2015
2. Д. Болд-Эрдэнэ. Улс төрийн философи: Удиртгал. УБ., 2015
3. М. Вебер. Улс төр бол мэргэшил мөн. шинжлэх ухаан бол мэргэшил мөн. УБ., 2000
4. Мишель до Монтень. Сонгомол эссеийүүд. УБ., 2005
5. М.Ф.Овсянников. Гегель. УБ., 1987
6. Философи. УБ., 2014.
7. Б. Чимид. Өнөөгийн улс төр хуульчийн нүдээр. УБ., 2006
8. Шарль Луй де Монтескье. Хуулийн Амин сүнс. УБ., 2008.

## Цахим эх сурвалж:

1. <https://ganaa.mn/2009/04/24/qwepmhkl/>
2. <http://www.news.mn/r/142360>